



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.12 оны 05 сарын 29-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

**Гоёо ХХК-ийн нийт гаргасан
хувьцааг худалдан авах тухай**

Говь ХК-ийн үйл ажиллагааны стратеги, хэтийн төлвийг харгалзан үзэж үйл ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр ашигтай, ашигтай ажиллагааг сайжруулах зорилгоор Гоёо ХХК-ийн нийт гаргасан болон эргэлтэнд байгаа хувьцааг худалдан авах асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 55.3-р зүйл, 76.1.17-р зүйл болон 92.1-р зүйл, Компанийн дүрмийн 6.2.7.15-р заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Ноолууран болон тэмээний ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2316161 регистрийн дугаартай Гоёо ХХК-ийн нийт гаргасан болон эргэлтэнд байгаа хувьцааны 100%-ийг бүрдүүлэх нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 21,056,968 ширхэг энгийн хувьцааг Таван Богд Трейд ХХК-иас худалдан авахаар **ШИЙДВЭРЛЭСҮГЭЙ.**

Хоёр. Гоёо ХХК-ийн нийт гаргасан болон эргэлтэнд байгаа хувьцаа буюу 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 21,056,968 ширхэг энгийн хувьцааны зах зээлийн үнийг 15,000,000 /арван таван сая/ ам.доллараар тогтоож Таван Богд Трейд ХХК-тай байгуулах хувьцаа худалдах, худалдан авах гэрээний үнээр **БАТАЛСУГАЙ.**

Гурав. Дээрхийн дагуу Гоёо ХХК-ийн нийт гаргасан болон эргэлтэнд байгаа хувьцааг худалдан авахтай холбогдох хувьцаа худалдах, худалдах авах гэрээг Таван Богд Трейд ХХК-тай байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайханд **ОЛГОСУГАЙ.**

Дөрөв. Таван Богд Трейд ХХК-иас Гоёо ХХК-ийн нийт гаргасан болон эргэлтэнд байгаа хувьцааг худалдан авах хэлцэл нь Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн сонирхлын зөрчилгүй гишүүд дээрхи асуудлыг хэлэлцэж олонхийн саналаар баталсан болохыг **ДУРДСУГАЙ.**



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.19 оны 05 сарын 29-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Тав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа-д **ДААЛГАСУГАЙ.**

ТУЗ-ийн сонирхлын зөрчилгүй ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

З.ШАГДАРСҮРЭН

ХИДЭО САВАДА

ТАКЭШИ КАМБЭ